



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/73

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн “Сумын 2024 оны төсөв батлах тухай” 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Төрийн байгууллагуудад шаардлагатай техник, тоног төхөөрөмж худалдан авах ажил”-д 102,300,000 (Нэг зуун хоёр сая гурван зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.“Төрийн байгууллагуудад шаардлагатай техник тоног төхөөрөмж худалдан авах ажил”-ын 102,300,000 (Нэг зуун хоёр сая гурван зуун мянга) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас зохих журмын дагуу анхан шатны баримт бичгийн бүрдлийг ханган зарцуулахыг нягтлан бодогч (Л.Цэнд-Аюуш)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжид хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА